

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



УЛААНБААТАР ХОТ  
2016 ОН



Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд нь хүн амын насны бүтэц, боловсролын байдлаас шууд хамаардаг бөгөөд “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг Үндэсний Статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар 2009 онд шинэчлэн баталснаар хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг “Ажиллах хүчний судалгааны”-ны үр дүнгээс тооцож байна.

“Статистикийн тухай” Монгол улсын хуулинд 2004 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 2006 оноос эхлэн “Ажиллах хүчний судалгаа”-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн тархаадаг болсон. Ажиллах хүчний судалгаанд дүүргийн 28 хорооноос сонгогдсон өрхөөс мэдээллийг сар бүр цуглуулж, улирлаар нэгтгэж үр дүнг тархаадаг.

Шинэчлэн батлагдсан аргачлалын дагуу ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцож гаргаснаар 2015 онд эдийн засгийн идэвхтэй хүн ам 118634 байгаагаас 109583 буюу 92.4 нь ажиллагчид, 6983 буюу 5.9 хувь нь ажилгүй иргэд байна.


Хүснэгт 1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт, 2010-2015 он

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
<b>15 ба түүнээс дээш насны хүн амын тоо</b>	198152	211455	215729	222973	228776	226067
<b>Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо</b>	97701	89894	94258	110429	108790	118634
• <b>Ажиллагчдын тоо</b>	91734	86492	87598	107637	103001	109583
• <b>Ажилгүй иргэдийн тоо</b>	5967	3402	6660	2792	2499	6983
• <b>Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо</b>	1164	5742	1446	2670	3290	2068
<b>Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо</b>	73649	70638	74897	95980	96472	97063
<b>Ажиллах хүчний оролцооны түвшин</b>	49.3	42.5	43.7	49.5	46.1	51.6
<b>Хөдөлмөр эрхлэлтийн түвшин</b>	93.9	96.2	92.9	97.5	94.7	92.4
<b>Ажилгүйдлийн түвшин</b>	6.1	3.8	7.1	2.5	2.3	5.9

Эдийн засгийн идэвхтэй хүн амд ажиллагсад болон ажилгүйчүүд багтана. Хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувиар тодорхойлогддог ажиллах хүчний оролцооны түвшин нь 51.6 байгаа бөгөөд өнгөрсөн оноос 5.5 пунктаар өссөн байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амын хэдэн хувийг ажил эрхэлж байгааг харуулдаг хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь 92.4 хувь байгаа нь 2015 онд дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10 хүн тутмын ойролцоогоор 9 нь ямар нэгэн ажил эрхэлдэг хүмүүс үлдсэн хувь нь эдийн засгийн идэвхгүй, эсвэл ажилгүй хүмүүс байна.

Зураг 1. Хүн амын хөдөлмөр эрхлэлт



Ажиллагсад гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинжэд хамрагдаж буй иргэнийг хэлдэг бөгөөд сүүлийн 6 жилийн үзүүлэлтээс харахад 2010 оноос 2011 онд 5242 хүнээр буюу 5.7 хувиар буурсан байхад өнгөрсөн оны мөн үеэс 6582 хүнээр буюу 6.4 хувиар буурсан харагдаж байна.

Ажилгүйдлийн түвшин 5.9 байгаа нь эдийн засгийн идэвхтэй 100 хүн тутмын ойролцоогоор 6 нь ажилгүй байгааг харуулж байна.

Эдийн засгийн ачаалал нь эдийн засгийн идэвхтэй болон идэвхгүй хүн амаар илэрхийлэгддэг бөгөөд эдийн засгийн ачаалал 81.8 хувь байгаа нь өмнөх оноос 6.9 пунктаар буурсан байна. Энэ нь эдийн засгийн ачаалал буурч байгааг харуулж байна.

Хүснэгт 2. Эдийн засгийн ачаалал, 2010-2015 он

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	97701	89894	94258	110429	108790	118634
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	73649	70638	74897	95980	96472	97063
Эдийн засгийн ачаалал*	75.4	78.6	79.5	86.9	88.7	81.8

\*-эдийн засгийн идэвхгүй хүн амыг идэвхтэй хүн амд харьцуулана

Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент нь сүүлийн жилүүдэд ойролцоогоор 4 хүн тутмын 1 нь эдийн засгийн идэвхтэй хүн байна.

Хүснэгт 3. Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент, 2010-2015 он

Үзүүлэлт	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
<b>Нийт хүн ам</b>	265997	283289	294908	304323	308672	320852
<b>Эдийн засгийн идэвхтэй хүн ам</b>	97701	89894	94258	110429	108790	118634
<b>Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент*</b>	36.7	31.7	32.0	36.3	35.2	37.0

\*-эдийн засгийн идэвхтэй хүн амыг нийт хүн амын тоонд харьцуулна

Эдийн засгийн үйл ажиллагааны бүх төрлийн салбарт ажиллагчдын тоо 2015 онд нийслэлийн дүнгээр 459970 байгаа ба манай дүүрэг 109582 буюу 23.8 хувийг эзэлж байна. Цалин хөлс олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

Хүснэгт 4. Ажиллагчдын тоо, ажилгүй иргэд, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, дүүрэг, хүйсээр, 2015 он

Дүүрэг	Ажиллагчид			Ажилгүй иргэд			Эдийн засгийн идэвхгүй хүн ам		
	эр	эм	бүгд	эр	эм	бүгд	эр	эм	бүгд
<b>Улаанбаатар</b>	246857	213113	459970	20387	13747	34134	163280	260426	423706
<b>Хан-Уул</b>	27664	25654	53318	2210	1470	3680	17830	28088	45918
<b>Багануур, Багахангай</b>	5392	4911	10303	357	159	516	6013	6701	12714
<b>Баянзүрх</b>	60650	48932	109582	5081	1901	6982	35222	61840	97062
<b>Налайх</b>	8073	6541	14614	805	1504	2309	3772	5484	9256
<b>Баянгол</b>	36996	34630	71626	3180	2981	6161	24088	37195	61283
<b>Сүхбаатар</b>	25240	21538	46778	1110	974	2084	17757	26546	44303
<b>Чингэлтэй</b>	24510	22134	46644	3380	2182	5562	20998	31455	52453
<b>Сонгинохайрхан</b>	58332	48773	107105	4264	2576	6840	37600	63117	100717

Ажиллах хүчний судалгааны дүнгээр Улаанбаатар хотод нийтдээ 34134 хүн ажилгүй байгаа ба үүний хамгийн их нь манай дүүрэгт 20.5 хувь буюу 6982 ажилгүй иргэн амьдарч байна. Ажилгүй иргэн гэдэг нь тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

Хүснэгт 5. Ажиллагчдын тоо, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо, насны бүлгээр 2015 он

Насны бүлэг	Ажиллагчид			Эдийн засгийн идэвхгүй хүн ам		
	эр	эм	бүгд	эр	эм	бүгд
<b>Бүгд</b>	60650	48932	109582	35222	61840	97062
<b>15-19</b>	491	359	850	11224	10143	21367
<b>20-24</b>	4939	4940	9879	5368	7653	13021
<b>25-29</b>	11549	8164	19713	2461	7537	9998
<b>30-34</b>	12437	8128	20565	1002	5523	6525
<b>35-39</b>	9697	9069	18766	1375	4230	5605
<b>40-44</b>	8246	6477	14723	1149	1915	3064
<b>45-49</b>	5016	6443	11459	971	2656	3627
<b>50-54</b>	4641	4170	8811	1678	3712	5390
<b>55-59</b>	2973	1004	3977	2318	6913	9231
<b>60-64</b>	496	-	496	3128	3721	6849
<b>65-69</b>	-	178	178	2265	3179	5444
<b>70 +</b>	166	-	166	2285	4658	6943

Ажиллагсдыг насны бүлгээр нь ангилбал 9.8 хувь буюу 10729 нь 15-24 насны, 53.9 хувь буюу 59044 нь 25-39 насны, 31.9 хувь буюу 34993 нь 40-54 насны, 4.4 хувь буюу 4816 нь 55-аас дээш насны хүмүүс байна.

Эдийн засгийн идэвхтэй хүн амыг насны бүлгээр ангилбал 35.4 хувь буюу 34388 нь 15-24 насны, 22.8 хувь буюу 22128 нь 25-39 насны, 12.4 хувь буюу 12081 нь 40-54 насны, үлдсэн 29.4 хувь буюу 28465 нь 55-аас дээш насны хүмүүс байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын тоо, эдийн үйл ажиллагааны салбараар 2015 он

Насны бүлэг	Ажиллагчид		
	эр	эм	бүгд
<b>Бүгд</b>	60650	48932	109582
<b>ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур</b>	843	230	1074
<b>Уул уурхай, олборлолт</b>	4086	483	4570
<b>Боловсруулах үйлдвэрлэл</b>	4974	4582	9556
<b>Цахилгаан, хий, уур, агааржуулалт</b>	650	164	814
<b>Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент</b>	583	352	935
<b>Барилга</b>	13082	2995	16076
<b>Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилг</b>	12085	13419	25504
<b>Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа</b>	7207	1367	8574
<b>Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ</b>	1944	4121	6065
<b>Мэдээлэл, холбоо</b>	2098	1049	3147
<b>Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа</b>	657	2259	2916
<b>Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа</b>	-	306	306
<b>Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа</b>	1210	860	2070
<b>Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа</b>	1819	2370	4189
<b>Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын</b>	5007	2724	7730
<b>Боловсрол</b>	1758	5283	7040
<b>Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа</b>	573	3719	4292
<b>Урлаг, үзвэр, тоглоом наадам</b>	1263	1073	2336
<b>Үйлчилгээний бусад үйл ажиллагаа</b>	811	1450	2261
<b>Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа</b>	-	126	126

Нийт ажиллагсдын хамгийн их нь буюу 23.3 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт, харин хамгийн бага нь буюу 0.1 хувь олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулдаг салбарт тус тус ажиллаж байна.

Хүснэгт 7. Ажиллагчдын тоо, эдийн үйл ажиллагааны салбараар, насны бүлгээр 2015 он

Насны бүлэг	ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах үйлдвэрлэл	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгэ	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	Мэдээлэл, холбоо	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа
<b>Бүгд</b>	1074	4570	9556	814	935	16076	25504	8574	6065	3147	2916	306	2070	4189	7730	7040	4292	2336	2261	126
<b>15-19</b>	-	-	-	-	-	182	126	-	543	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>20-24</b>	334	426	999	-	-	1303	1997	1033	810	434	251	144	-	369	772	164	-	340	502	-
<b>25-29</b>	-	967	2155	328	170	3101	3597	1443	969	1058	1386	-	555	753	1324	445	728	581	153	-
<b>30-34</b>	150	858	1477	-	352	2619	5112	1239	366	899	620	-	492	723	2338	1836	711	342	305	126
<b>35-39</b>	176	834	788	139	-	2763	5374	964	858	157	-	-	540	871	1437	1955	792	290	828	-
<b>40-44</b>	-	512	1153	-	230	2725	3526	1351	1433	259	182	162	329	508	654	782	643	272	-	-
<b>45-49</b>	414	195	1217	164	182	1624	3036	787	612	164	167	-	-	320	577	1354	306	181	160	-
<b>50-54</b>	-	493	1264	184	-	955	1912	614	320	176	310	-	-	516	325	323	927	178	313	-
<b>55-59</b>	-	285	502	-	-	806	478	985	154	-	-	-	-	128	119	182	185	152	-	-
<b>60-64</b>	-	-	-	-	-	-	-	158	-	-	-	-	153	-	185	-	-	-	-	-
<b>65-69</b>	-	-	-	-	-	-	178	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
<b>70+</b>	-	-	-	-	-	-	166	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Хүснэгт 8. Ажиллагчдын тоо, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэр, насны бүлгээр 2015 он

Насны бүлэг	Компани	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Төсөвт байгууллага	Улсын үйлдвэрийн газар	Төрийн бус байгууллага
<b>Бүгд</b>	57663	26326	19587	3740	1853
<b>15-19</b>	725	126	-	-	-
<b>20-24</b>	7099	1293	1100	388	-
<b>25-29</b>	12059	2932	3449	1091	182
<b>30-34</b>	10522	4423	4534	424	662
<b>35-39</b>	9099	5813	3503	167	184
<b>40-44</b>	7517	4438	2001	465	301
<b>45-49</b>	4902	2960	2591	593	
<b>50-54</b>	4007	2098	1937	612	157
<b>55-59</b>	1576	1899	319		182
<b>60-64</b>	158	-	153	-	185
<b>65-69</b>	-	178	-	-	-
<b>70+</b>	-	166	-	-	-

Дүүргийн нийт ажиллагчдыг ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр нь ангилбал 52.8 хувь буюу 57663 нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани, 24.1 хувь буюу 26326 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 17.9 хувь буюу 19587 нь төрийн төсөвт байгууллага, 3.4 хувь буюу 3740 нь төрийн өмчит болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 1.8 хувь буюу 1853 нь төрийн бус байгууллагад тус тус ажиллаж байна.

Хүснэгт 9. Ажиллагчдын тоо, хөдөлмөр эрхлэлтийн статус, насны бүлгээр 2015 он

Насны бүлэг	Цалин хөлстэй ажиллагч	Ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Мал аж ахуй эрхлэгч	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч
<b>Бүгд</b>	78934	2542	25845	414	1847
<b>15-19</b>	725	-	126	-	-
<b>20-24</b>	8939	-	940	-	-
<b>25-29</b>	16856	-	2723	-	133
<b>30-34</b>	15379	509	4379	-	298
<b>35-39</b>	12199	413	5767	-	388
<b>40-44</b>	8967	773	4454	-	528
<b>45-49</b>	6861	557	3293	414	334
<b>50-54</b>	6404	162	2245	-	-
<b>55-59</b>	2108	128	1574	-	166
<b>60-64</b>	496	-	-	-	-
<b>65-69</b>	-	-	178	-	-
<b>70+</b>	-	-	166	-	-

Ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар нь ангилбал 72.3 хувь буюу 78934 нь цалин хөлстэй ажиллагч, 2.3 хувь буюу 2542 нь ажил олгогч, 23.7 хувь буюу 25845



нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 0.4 хувь буюу 414 нь мал аж ахуйн эрхлэгч, 1.3 хувь буюу 1847 нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байна.

Хүснэгт 10. Ажиллагчдын тоо, боловсролын түвшнээр, насны бүлгээр 2015 он

Насны бүлэг	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын дээд болон бакалавр	Магистр	Доктор
<b>Бүгд</b>	167	1024	4030	10923	34798	4856	49002	4470	313
<b>15-19</b>	-	-	182	302	366	-	-	-	-
<b>20-24</b>	-	157	166	1130	3439	160	4683	144	-
<b>25-29</b>	-	183	939	2285	4536	326	10948	496	-
<b>30-34</b>	-	-	572	2254	5757	305	10197	1480	-
<b>35-39</b>	167	-	590	2541	5739	726	8132	743	128
<b>40-44</b>	-	-	349	1258	6239	603	5503	772	-
<b>45-49</b>	-	182	628	659	3510	1213	4616	650	-
<b>50-54</b>	-	166	292	495	3297	1089	3472	-	-
<b>55-59</b>	-	157	312	-	1596	434	1292	185	-
<b>60-64</b>	-	-	-	-	153	-	158	-	185
<b>65-69</b>	-	178	-	-	-	-	-	-	-
<b>70+</b>	-	-	-	-	166	-	-	-	-

2015 оны байдлаар дүүрэгт ажиллаж буй ажиллагчдыг боловсролын түвшнээр нь ангилбал 0.2 хувь буюу 167 нь боловсролгүй, 0.9 хувь буюу 1024 нь бага, 3.7 хувь буюу 4030 нь суурь, 10.0 хувь буюу 10923 нь бүрэн дунд, 31.9 хувь буюу 34798 нь техникийн болон мэргэжлийн, 4.4 хувь буюу 4856 нь тусгай мэргэжлийн дунд, 44.9 хувь буюу 49002 нь дипломын дээд болон бакалаврын боловсролтой, 4.1 хувь буюу 4470 нь магистрын боловсролтой бол үлдсэн 0.1 хувь буюу 313 нь докторын боловсролтой ажиллагчид байна.

Эдийн засгийн идэвхгүй хүн аманд суралцдаг, сурахаас явах гэж байгаа, тэтгэврийн, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хасвал 31078 иргэн ямар нэг шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй байна.

Хүснэгт 11. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар, насны бүлгээр 2015 он

Насны бүлэг	Гэрийн ажилтай	Суралцаг	Сурахаар явах гэж байгаа	Тэтгэвэрт	Өндөр настан	Хөгжлийн бэрхшээлтэй	Ажил хийхийг хүсээгүй	Хүүхэд асарсан	Өвчтэй байсан	Өвчтөн, өндөр настан асарсан	Бусад
<b>Бүгд</b>	10956	30138	824	28823	547	5652	1119	14080	1381	153	1478
<b>15-19</b>	827	19006	181	-	-	356	328	183	-	153	-
<b>20-24</b>	930	8958	170	-	-	-	-	2243	182	-	232
<b>25-29</b>	1516	1826	146	-	-	1057	304	4449	390	-	-
<b>30-34</b>	1249	348	164	-	-	461	176	3797	330	-	-
<b>35-39</b>	1470	-	-	-	-	903	128	2206	319	-	232
<b>40-44</b>	775	-	164	-	-	303	182	666	-	-	476
<b>45-49</b>	1392	-	-	152	-	1213	-	360	160	-	232
<b>50-54</b>	1843	-	-	2187	-	876	-	176	-	-	307
<b>55-59</b>	954	-	-	7795	-	483	-	-	-	-	-
<b>60-64</b>	-	-	-	6302	547	-	-	-	-	-	-
<b>65-69</b>	-	-	-	5444	-	-	-	-	-	-	-
<b>70+</b>	-	-	-	6942	-	-	-	-	-	-	-

Хөдөлмөр эрхлээгүй дээрх 31078 иргэний 35.2 хувь буюу 10956 нь гэрийн ажилтай, 3.6 хувь буюу 1119 нь ажил хийхийг хүсээгүй, 45.3 хувь буюу 14080 нь хүүхэд асардаг, 4.9 хувь буюу 1534 нь өөрөө өвчтэй болон өвчтөн, өндөр настан асардаг, 1510 хувь буюу 1478 нь бусад шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй байна.

Нэгтгэн боловсруулсан мэргэжилтэн:

Б.Эрхэмбаяр

Хянасан хэлтсийн дарга:

Н.Энхтуяа

Цахим хаяг: [www.nso.mn](http://www.nso.mn)

[www.1212.mn](http://www.1212.mn)

[www.ubstat.mn](http://www.ubstat.mn)

E-mail: [bayanzurkh@nso.mn](mailto:bayanzurkh@nso.mn)

Утас: 267349, 261728, 261019